

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН
2023 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар16

“ГТХЗНТ” УТУГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“ГТХЗНТ” УТУГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн батлуулсан нэгжүүдийн 9 дүгээр сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

Үнэлэлт

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажил	Үүнээс							Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%	ҮӨ	
ЗСХ	14	7	3	1	1	1	-	1	85.9
ТНУАСХ	14	14	-	-	-	-	-	-	100
ГХБАБМХ	13	10	-	2	-	-	-	1	95.0
Дүн	41	31	3	3	1	1	-	2	93.8

Дүгнэлт

1. Нэгжүүд 2023 оны 9 дүгээр сард нийт төлөвлөсөн 41 ажлаас 93.8 хувийг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба 6.2 хувийг хэрэгжүүлж дуусаагүй (үүнд: 5 ажил) байна.
2. Нэгжүүдийн албан бичиг шийдвэрлэлт 51.4 хувьтай байна. 9 дүгээр сард хариу өгөх хугацааг хоцроож шийдвэрлэсэн 1, хариу хүргүүлээгүй буюу шийдвэрлээгүй 2, шийдвэрлэгдэх шатанд 16 өргөдөл хүсэлт байна.

Санал зөвлөмж

1. 2023 оны 9 дүгээр сарын төлөвлөгөөнд гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч хэрэгжилтийн шатанд байгаа ажлуудыг дараа сарын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж дуусгах;
2. Сарын биелэлтийг тайлагнахдаа хийсэн ажлын үр дүн, ач холбогдолыг бүрэн гүйцэд, товч, тодорхой бичиж, огноо, албан бичгийн дугаар зэрэг мэдээллийг оруулж, шаардлагатай тайлан мэдээллийг хавсаргаж байх;

3. Сайдын шуурхай хуралдаанаас төвд 21 үүрэг даалгаврыг өгсөн бөгөөд 70 хувийн хэрэгжилттэй 2, 30 хувийн хэрэгжилттэй 1, хугацаа болоогүй 2, үнэлгээ өгөөгүй 2, хэрэгжилт 91.9 хувьтай байна.
3. Албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж буй эсэхэд нэгжийн удирдлага, ахлах мэргэжилтэн нараас тавих хяналтыг сайжруулах, хариу өгсөн, шийдвэрлэсэн тухай мэдээллийг албан бичгийн бүртгэлийн системд тухай бүрд оруулж хэвших;
4. Ажилтнуудын ажлын цаг ашиглалтыг сайжруулахад удирдлагаас болон цагийн бүртгэл хариуцсан ажилтнаас тавих хяналтыг сайжруулах;
5. 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;
6. Зам, холбоо дохиолол, хөдөлгөөн, вагон, зүтгүүрийн мэргэжилтэй болон бусад ажилтнууд ЗТХЯ-ны цахим хуудсанд байршуулсан төмөр замын тээврийн 16 дүрэм, журмын төсөлтэй танилцаж 2023.10.22-ны дотор цахим шуудангаар болон сэтгэлдэлээр санал өгөх ажиллагаанд идэвхтэй оролцох.

ТАНИЛЦСАН:

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

ТНУАСХ-ИЙН ДАУТУГ

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮМ



А.БУЯННЭМЭХ

Ц.ОЮУНБАТ

Б.БУМАНЦЭЦЭГ

Э.ОСОРЖАМАА